


Захирлын 2022 оны 12 дугаар сарын
18 ны өдрийн 137 дугаар тушаалын
хавсралт



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ БОЭТ-ИЙН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ :

- 1.1 Удирдлагын баг нь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах хэрэгжүүлэх, дотоод зохион байгуулалт, аж ахуйн, санхүүгийн үйл ажиллагаа, хүний нөөц, ажилтны нийгмийн баталгааг сайжруулах асуудлаар бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захиралд зөвлөх үүрэгтэй.
- 1.2 Удирдлагын багийн чиг үүрэг, эрх, ажиллах холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.
- 1.3 Удирдлагын баг нь төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай, Хөдөлмөрийн тухай хууль тогтоомж болон бусад холбогдох хууль, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн дүрэм болон Хөдөлмөрийн дотоод журам, бусад журмыг удирдлага болгоно.
- 1.4 Удирдлагын баг нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй бөгөөд түүний үйл ажиллагааны хэлбэр нь удирдлагын багийн хуралдаан байна.
- 1.5 Удирдлагын баг нь: Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал, Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал, Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны дарга, Гүйцэтгэлийн удирдлага дотоод хяналтын албаны дарга, Санхүүгийн албаны дарга, Хүний нөөцийн менежер, Сургалтын менежер, Поликлиникийн албаны дарга, Дэмжих төвийн дарга, Сувилахуйн албаны дарга нарын бүрэлдэхүүнтэй ажиллана.
- 1.6 Удирдлагын баг нь хурлын бэлтгэл, ажиллах нөхцөлийг бичиг хэргийн ажилтан хариуцан хангана.

ХОЁР. УДИРДЛАГЫН БАГИЙН ЧИГ ҮҮРЭГ

- 2.1 Удирдлагын баг дараах асуудлыг хэлэлцэнэ.
 - 2.1.1 Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэх, түүний биелэлтийг дүгнэх
 - 2.1.2 Үйл ажиллагааг жигд тасралтгүй, чанартай явуулахын тулд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн дотоод зохион байгуулалт, дэг журмыг сайжруулах, энэ талаарх журам, зааврын төслийг хэлэлцэх, хяналт тавьж чиглүүлэх
 - 2.1.3 Эд хөрөнгийн тооллогын дүн, ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдлын талаар хэлэлцэх
 - 2.1.4 Ажилтнуудыг шагнаж урамшуулах, тусламж дэмжлэг үзүүлэх, сахилгын шийтгэл ногдуулах асуудлыг хэлэлцэх

- 2.1.5 Ажилтанд үр дүнгийн, ур чадварын нэмэгдэл хөлс олгох болон цалин хөлсийг нэмэгдүүлэх, нийгмийн баталгаагаар хангах асуудлыг хэлэлцэх
- 2.1.6 Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сонгон шалгаруулах болон хүний нөөцийг бэхжүүлэхтэй холбогдсон бусад асуудал
- 2.1.7 Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн гадаад харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэгдсэн санал санаачлага, үзэл баримтлалуудыг хэлэлцэх
- 2.1.8 Тасаг нэгжийн жилийн ажлын төлөвлөгөө, тайланг хэлэлцэх
- 2.1.9 Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн тулгамдаж буй бусад асуудлыг хэлэлцэх, шийдвэрлэх
- 2.1.10. Хэлэлцэх асуудлаас хамааран үйлдвэрчний эвлэлийн төлөөлөгчийг оролцуулж хурлыг өргөтгөж болно.
- 2.1.11 Удирдлагын зөвлөл нь БОЭТ-ийн үйл ажиллагааг сурталчилах иргэдэд мэдээлэх, иргэдээс мэдээлэл хүлээн авах, асуумж судалгааг авч хэрэгжүүлэх бөгөөд үр дүнг зохих журмын дагуу эргэн мэдээлэх, мэдээллийн хэрэгслээр түгээн ажиллана.
- 2.1.12 Эмнэлгийн тусламж үйлчилгээнд иргэдийн хэрэгцээг тэргүүнд тавьж, тусламж үйлчилгээний чанар, ээлтэй орчинг бүрдүүлэхэд шаардагдах нөөц, хөрөнгийг зөв хуваарилан, дээд шатны байгууллага, орон нутгийн төрийн болон, төрийн бус байгууллагуудтай хамтран гүйцэтгэнэ.

ГУРАВ. УДИРДЛАГЫН БАГИЙН ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 3.1 Удирдлагын баг сард 2-оос доошгүй удаа хуралдах ба хурлын тов, хэлэлцэх асуудал, танилцуулга материалыг гишүүдэд урьдчилан мэдэгдэнэ.
- 3.2 Удирдлагын багийн гишүүдийн олонх буюу 60-аас дээш хувь хүрэлцэн ирснээр хурал хүчин төгөлдөр байна.
- 3.3 Хурлаар хэлэлцэх асуудлыг гишүүдэд бичгээр урьдчилан танилцуулсан байна.
- 3.4 Удирдлагын багийн гишүүд хурлаар хэлэлцэж байгаа аливаа асуудлаар шийдвэр гаргах үед дэмжих, татгалзах, түдгэлзэх эрхийг хэрэгжүүлнэ.
- 3.5 Удирдлагын багийн гишүүд хурлаар хэлэлцэх асуудлыг хойшлуулах, дахин хянан үзэх санал гаргах эрхтэй.
- 3.6 Хурал даргалагч /Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал/ хэлэлцүүлсэн асуудлын талаар гарсан саналыг нэгтэн дүгнэж эцсийн шийдвэрийг гаргана.
- 3.7 Удирдлагын багийн хурлын тэмдэглэлийг Хүний нөөцийн менежер хөтөлж, хурал даргалагчид танилцуулан, гарын үсэг зурж баталгаажуулна.
- 3.8 Удирдлагын багийн хэлэлцсэн асуудлаар гарах шийдвэрийн төслийг хуралд санал оруулсан гишүүд хариуцан боловсруулж, биелэлтийг хангах арга хэмжээ авна.

ДӨРӨВ. УДИРДЛАГЫН БАГИЙН ГИШҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1 Удирдлагын багийн гишүүн дор дурьдсан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.
- 4.2 Удирдлагын багийн хуралд хүндэтгэх шалтгаангүй бол заавал хүрэлцэн ирж оролцох, хэлэлцсэн асуудлаар санал гаргах

- 4.3 Удирдлагын багаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлэх;
- 4.4 Удирдлагын багийн ажиллах журамд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Захирал болон удирдлагын багт гаргах
- 4.5 Удирдлагын зөвлөлийн гишүүд нь аливаа асуудлыг багаараа хэлэлцэн шийдвэрлэж, өөрийн ёс зүй, хариуцлагыг эрхэмлэн асуудалд шударга, бүтээлчээр хандах, хурлын шийдвэрийг албан бусаар нийтэд мэдээлэхгүй байх зарчмыг мөрдлөг болгоно.
- 4.6 Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанаас бусад байгууллагын хөгжил, удирдлага, эмчилгээ үйлчилгээний чанар хүртээмж, санхүү эдийн засгийн төлөвлөлт, түүний гүйцэтгэл зэргийг зөв хуваарилалт зохион байгуулалтаар ханган ажиллана.
- 4.7 Удирдлагын зөвлөлийн гишүүд цаг үеийн асуудлаар өөрийн чиг үүрэгт заагдаагүй үүрэг, даалгаврыг богино хугацаанд чанартай гүйцэтгэж тайлагнах үүрэгтэй.
- 4.8 Удирдлагын зөвлөлийн гишүүд нь хамтран ажиллах, бие биенээ дэмжих, багаараа үр дүнтэй ажиллах ба байгууллагын захиралд ажлаа улирал бүр дүгнүүлэн ажиллаж, ажлын үр дүнгээс хамааран гишүүдийг урамшуулна.
- 4.9 Төлөвлөгөөнд тусгагдсан ажилд бүтээлчээр хандаагүй, биелэлт хангалтгүй , тайланг товч, дүгнэхэд хялбар байдлаар нэгтгээгүй тохиолдолд цалин урамшуулалд нэмэгдэл тооцохгүй байх үүргийг байгууллагын захирал хүлээнэ.
- 4.10 Байгууллагын үйл ажиллагааг олон талаас дүгнэн, үйл ажиллагааны төлөвлөгөө, ажлын үр дүнг үнэлж, хамтран хэрэгжүүлэх баг хамт олонд санал тавьж, богино хугацаанд сайжруулан, түүнд шаардагдах нөөц боломжийг захирал болон санхүүгийн албанаас нэхэмжлэх эрхтэй байна.
- 4.11 Гишүүд өөрсдийн санаачлагаар асуудал дэвшүүлэн клиник, албадуудад хэрэгжүүлэх, хамтын үйл ажиллагааг өргөжүүлэхэд анхаарах, эмч мэргэжилтнүүдэд зарчмын шаардлага тавих, түүнийг хэрэгжүүлэхээр бие сэтгэлээ дайчлан ажиллаж, чанар бүтээмжийг нэмэгдүүлэхэд оролцоогүй, дэмжлэг туслалцаа үзүүлээгүй эмч, албадад хариуцлаг тооцуулахаар захирал, удирдлагын багт санал, хүсэлтээ гаргах эрхтэй бөгөөд үүнийг сурталчлан мэдээлэх үүргийг хүлээнэ.

ТАВ . ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

- 5.1 БОЭТ-ийн захирал нь удирдлагын зөвлөлийн гишүүдийн үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хамтран ажиллах, холбогдох санал хүсэлтийг хэрэгжүүлэхэд анхааран дэмжлэгт удирдлагаар ханган ажиллана.
- 5.2 Удирдлагын зөвлөл нь байгууллагын клиник, тасаг нэгжийн үйл ажиллагаа сонгосон ажил үйлчилгээнд хяналт тавин хэрэгжүүлж, мэргэжлийн багаар байнгын болон явцын хяналт шинжилгээ, үнэлгээг хийж хэрэгжүүлнэ.
- 5.3 Байгууллагын төлөвлөгөө, гүйцэтгэлийн үнэлгээнд ач холбогдол өгч, хөрөнгө мөнгө, цаг хугацаа их зарцуулах ажилд шаардагдах боломж, гарцыг тооцоолон ажиллаж санхүүгийн хэмнэлт гаргах, удирдлагын шат дамжлагын урсгалыг багасган ажиллана.

ЗУРГАА. ЖУРАМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ БА ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

6.1 Удирдлагын багийн ажиллах журамд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг байгууллагын дарга болон удирдлагын багийн гишүүд гаргаж болно.

6.2 Нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Захирал болон Удирдлагын баг, Удирдлагын зөвлөлийн өргөтгөсөн хурлаар хэлэлцэж Захирал батлах бөгөөд баталсан тухай захирлын тушаал гаргаснаар хүчин төгөлдөр болно.